

**Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх материалын жагсаалт**

д/д	Бүрдүүлэх материалын жагсаалт	Тавигдах шаардлага
1	Тухайн төрөлжсөн мэргэшлээр гадаадын эмнэлгийн мэргэжилтэн зайлшгүй ажиллуулах хэрэгцээг тодорхойлсон <b>албан бичиг</b>	Зөвшөөрөл хүсч буй хугацаа, ажиллуулах хэрэгцээг дэлгэрэнгүй бичих.
2	Гүйцэтгэх ажил үйлчилгээний <b>төлөвлөгөө</b>	Байгууллагын даргаар батлуулсан гарын үсэг, тамгатай байх.
3	Байгууллагын эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх <b>тусгай зөвшөөрлийн</b> хуулбар	Нотариатаар батлуулсан байх.
4	Гадаадын эмнэлгийн мэргэжилтний <b>танилцуулга</b> /энэхүү тушаалын наймдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу/	Байгууллагын даргын гарын үсэг, тамгатай байх.
5	Гадаадын эмнэлгийн мэргэжилтний <b>паспорт</b> , түүнийг орлох хууль ёсны баримт бичгийн хуулбар, баталгаат монгол орчуулгын хамт	Монгол Улсад оршин суух үнэмлэхтэй бол түүний хуулбарыг хамт авчрах.
6	Гадаадын эмнэлгийн мэргэжилтний <b>мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл</b> буюу түүнтэй адилтгах хүчин төгөлдөр баримт бичгийн хуулбар, баталгаат монгол орчуулгын хамт	Тухайн улсын эрх бүхий байгууллагын англи хэл дээрх хувилбар /тодорхойлолт/-ын хамт өгөх.
7	<b>Анагаах ухааны</b> чиглэлээр боловсрол эзэмшсэнийг <b>нотлох үнэмлэх, диплом</b> түүнтэй адилтгах хүчин төгөлдөр баримт бичгийн хуулбар, баталгаат монгол орчуулгын хамт	Тухайн улсын эрх бүхий байгууллагын англи хэл дээрх хувилбар /тодорхойлолт/-ын хамт өгөх.
8	<b>Төрөлжсөн мэргэшлийн</b> чиглэлээр суралцсаныг <b>нотлох хүчин төгөлдөр баримт бичгийн</b> хуулбар, баталгаат монгол орчуулгын хамт	Тухайн улсын эрх бүхий байгууллагын Англи хэл дээрх хувилбар /тодорхойлолт/-ын хамт өгөх.
9	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагуудын <b>лавлагаа</b>	- <b>ХХҮЕГ</b> - <b>ГИХГ-ын Виз, зөвшөөрөл, харьяатын газар</b> - <b>МХЕГ</b> /зөвшөөрөл давтан хүссэн тохиолдолд/ <i>/Визний ангилал харгалзахгүй бүх мэргэжилтэнд хамаарна/</i>
10	Энэхүү журмын 3.4-т заасан шалгуурыг хангасныг нотлох <b>орчуулагчийн</b> баримт бичгийн баталгаат хуулбар	- Тухайн хэлийг дээд түвшинд эзэмшсэн. - Эрүүл мэнд, анагаах ухааны чиглэлээр орчуулга хийж байсан.
11	Байгууллагын гадаад мэргэжилтэнтэй байгуулсан <b>гэрээ</b> /эсвэл байгууллага хоорондын-Засгийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв нь гадаадын мэргэжилтний үндсэн байгууллагатай урт хугацаагаар байгуулсан гэрээний хуулбар/	Журмын 3.3-т заасан нөхцлийг заавал тусгасан байх, зөвшөөрөл хүссэн хугацаанд хүчин төгөлдөр байх.
12	Байгууллагын <b>улсын бүртгэлийн гэрчилгээний</b> хуулбар	Нотариатаар батлуулсан байх.
13	Урьд нь лиценз авч байсан бол <b>лицензийн хуулбар</b>	Өмнөх лицензийг он оноор авчрах.
14	Зөвшөөрлийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын <b>тайлан</b>	Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн өөрөө бичиж гарын үсэг зурсан байх /орчуулгын хамт/

15	3x4 хэмжээтэй зураг 2%	Сүүлийн нэг жилийн хугацаанд авхуулсан байх.
----	------------------------	--

**ЖИЧ:** - Байгууллагын албан тоотод тухайн мэргэжилтний бүрдүүлсэн материалын хуудасны тоог тавьж танилцуулгын маягыг хүн бүрээр гаргаж хавсаргасан байна.

- Байгууллагын товч танилцуулга, байгууллагын даргын орон тоо баталсан тушаал /эмнэлгийн мэргэжилтнүүдийн лиценз, бакалаврын болон мэргэшлийн дипломын хамт/, ор баталсан тушаал /ортой эмнэлэгт хамаарна/ зэргийг хавсаргаж өгөх.
- Тэмдэгтийн хураамж **120.000** төгрөгийг лиценз гарсны дараа төлж, баримтыг авчирч өгнө.